

НЭГЭН ХУВРАГИЙН МОНГОЛЫН ТӨРД ӨРГӨСӨН БИЧГИЙН УЧИР

Б.ДЭЛГЭРМАА

Товч агуулга: Тус өгүүллээр Цэцэрлэг Мандал аймгийн Хотонт уулын хошууны гэлэн Очироос БНМАУ-ын Бүх Шашны Хэргийг Эрхлэх Газарт өргөсөн бичиг болон тус газар хянаад илгээсэн бичиг тус бүрийг эрх зүйн түүхийн ухааны үүднээс шинжлэн тайлбарлахыг зорив. Энэ баримт Үндэсний Төв Архивын Улс төр, нам олон нийтийн байгууллагын баримтын төвийн Х-4, Д-1, ХН- 446, 474-р баримтанд буй. 1929-1938 онд МАХН-аас шашныг хязгаарлахад чиглэсэн бодлого тууштай хэрэгжүүлснийг нотлохуйц 1925 оны буюу шилжилтийн зурвас үеийн энэ сурвалжид гаргалгаа хийхийг хичээлээ.

Түлхүүр үг: Гэлэн, хувраг, МАХН-ын Төв Хороо, Намын үүр, БНМАУ-ын Бүх Шашны Хэрэг эрхлэх газар, Өргөх бичиг

Судлагдсан байдал

Монголын бурханы шашны түүхийн талаарх системтэй судалгаанууд 19 дүгээр зууны эхэн үеэс эхэлсэн бөгөөд бурханы шашны түүхийн олон талын судалгаа хийгдсэн байна. Монголын эрдэмтэн судлаачид төдийгүй гадны эрдэмтэд бурханы шашны тархалт, хөгжлийн түүхэн үйл явц, монгол улсын улс төр, эдийн засаг, соёлын амьдралд үзүүлсэн нөлөө, буддын шашны гол дүрүүдийн намтар, төр шашныг тусгаарлах үйл явц, төрийн бодлого болон сүм хийдийн дүрэм журам зэргээр олон тооны бүтээл туурвижээ. Эдгээрээс доктор С.Пүрэвжав, Д.Дашжамц, Б.Дашзэвэг нарын нэгэн сэдэвт бүтээл¹ чухал байр суурь эзэлнэ. Эдгээр эрдэмтэд нэгэн сэдэвт бүтээлээрээ Монгол дахь шарын

¹ Пүрэвжав, С., Дашжамц, Д. *БНМАУ-д сүм, хийд лам нарын асуудлыг шийдвэрлэсэн нь (1921-1940 он)*, Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар, 1965.

Пүрэвжав, С. *Монгол дахь шарын шашны хураангуй түүх*, Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар, 1978.

Дашцэвэг, Б. *МАХН-наас шарын шашин, түүний үлдэгдлийн эсрэг явуулсан тэмцлийн зарим асуудал*, Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар, 1976.

шашны түүх болон 20 дугаар зуунд төрөөс, МАХН-аас шашны талаар явуулсан бодлогыг судлахдаа хууль, эрх зүйн зохицуулалтыг авч үзжээ. Академич Ж.Болдбаатар,² доктор Д.Цэдэв,³ С.Цэдэндамба⁴ зэрэг эрдэмтдийн судалгааны бүтээлд шашны эрх зүйн зохицуулалт, дүрэм журам тодорхой хэмжээгээр тусгагдсан байна. Судлаач А.Жамбалын Монгол улс дахь шашин шүтлэгийн эрх зүйн зохицуулалт“ (1206-1936 он) хэмээх нэгэн сэдэвт бүтээл нь төрөөс шашин шүтлэгийн талаар авсан арга хэмжээ, төрийн бодлогыг системчлэн судалснаараа онцлог юм. Хэдийгээр шашны эрх зүйн зохицуулалт, сүм хийдийн дүрэм, жаяг, хэм хэмжээгээр тусгайлсан судалгааны ажлууд хийгдэж байгаа хэдий ч бидний судалгаа тухайн дүрэм, журам хэрхэн мөрдөгдөж, хэрэгжиж байсныг тодруулахад нэмэр болох болов уу. Нөгөөтэйгүүр төр-шашны харилцааг зохицуулах шинэ эрх зүйн тогтолцоо дөнгөж бүрэлдэн бий болж байсан цаг үед улс төрийн большевик үзэл санаа хэрхэн оролцож нөлөөлсөн явдлыг судлах шаардлагатай байна.

Түүнчлэн судалгааны объект болох гэлэн Очирын мэдүүлсэн гомдол нь МАХН-аас шашны хэрэгт шууд оролцох болсныг лам хуврагууд эрс эсэргүүцэж байсны бодит нотолгоо төдийгүй төр, шашны харилцааг тусгаарлах үйл явцад төр-шашин-нам гурвын харилцаанд гарсан зөрчил, шашныг хязгаарлах бодлого эрх зүйгээр дамжин орон нутагт хэрхэн илэрч, ямар эсэргүүцэлтэй тулгарч байсан болон шийдвэрлэхдээ хууль, журмаа баримталж байсан эсэхийг тодруулахыг зорьсон, анхны жишгүүдийн нэг болсоноороо онцлог бөгөөд ач холбогдолтой юм. Иймээс тус өгүүллээр Цэцэрлэг Мандал аймгийн Хотонт уулын хошууны гэлэн Очирын БНМАУ-ын Бүх Шашны Хэргийг Эрхлэх Газарт болон МАН-ын Төв Хороонд өргөсөн бичиг, БНМАУ-ын Бүх Шашны Хэргийг Эрхлэх Газраас Намын Төв Хороонд илгээсэн бичигт эрх зүйн шинжилгээ хийх болно.

Архивын баримтыг тайлбарлах нь

Дурдан буй баримтуудыг Монгол улсын арван тавдугаар (1925) оны арван сарын 17, 27, 29-ний өдрүүдэд огноолсон бөгөөд аргын тоолол хэрэглэн үйлджээ. Энэ нь тухайн үед мөрдөж байсан албан бичгийн хэм хэмжээний дагуу бичигдсэн бөгөөд аргын тоолол хэрэглэх тухай 1921 оны 5 сарын 20-нд Ардын түр засгийн газраас (цаашид АТЗГ гэх) хэлэлцсэн асуудлын гуравдугаар зүйлд, элдэв албан

² Болдбаатар, Ж. *Монголын бурханы шашны лам хувраг*, Улаанбаатар: Соёмбо Принтинг ХХК, 2010.

³ Цэдэв, Д. *Их шавь*, Улаанбаатар: Улсын хэвлэлийн үйлдвэр, 1964.

⁴ Цэдэндамба, С. *Монгол улс дахь шашны нөхцөл байдал (XX-XXI зууны зааг үе)*, Улаанбаатар, 2003.

бичигт Монгол Улсын олноо өргөгдсөний тоолол ба европын тоолол хоёрыг хавсран бичиж явуулсаар байхыг тогтсон байдаг⁵. БНМАУ-ын анхдугаар их хурлын 14 дүгээр тогтоолын гуравдугаар зүйлд, Ерөнхий сайд Цэрэндоржоос аливаа албан газрууд ба албаны хэрэгт хуучин цаг улирлын тоог хэрэгсэхгүй болгон хасаж, аргын улирлын цаг тоогоор явуулах нь зүйтэй хэмээн тогтоожээ⁶. Энэ нь өвлийн дунд сарын шинийн долооны өдрөөс аргын улирлын 1 дүгээр сарын 1 болох тул, мөн өдрөөс эхлэн 15 дугаар оны цагаан сарын шинийн нэгэн хэмээн хэлж аргын улирлын цаг тоог хэрэглэвээс зохихыг 34 хошуу, шавийн газар хүргүүлсэн 1924 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн чуулган даргын бүгдийг эрхлэх түшмэл Довчинжамц⁷ гэсэн нэртэй баримтаас үзэхэд, Монгол улс 1925 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс Григорийн тоололд шилжсэн хэдий ч албан баримтад хоёр төрлийн он тоолол хавсран хэрэглэгдсээр байсныг энэхүү өгүүлэлд шинжилж буй баримт төдийгүй бусад архивын баримтаас мэдэж болно. Улмаар Монгол Улс 1946 оны 1 дүгээр сарын 1-нээс григорийн тоололд албан ёсоор шилжсэн байна.

Өргөх бичигт дурдсан үйл явдал байршлын хувьд хаана болсныг тодруулахад, Цэцэрлэг мандал уулын аймгийн Хотонт уулын хошуу нь одоогийн Архангай аймгийн Хотонт сум болно. Тус хошуу нь манжийн ноёрхлын үед Сайн ноён аймагт, хавсран захирагдсан Өөлдийн өмнөд хошуу, Богд хаант улсын үед Сайн ноён хан аймгийн Сүжигт засгийн хошуу гэж явжээ. 1923-1931 онуудад Цэцэрлэг мандал уулын аймгийн Хотонт уулын хошуу гэж нэртэй, Дэлгэрбадрах гэж нэг сумтай яваад 1925 онд Эрдэнэбулган уулын хошуунд нийлсэн байна⁸.

Ерөөс Ардын хувьсгал ялснаас хойш, Монгол Улсад засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хувьд томоохон өөрчлөлт хийх эрх зүйн үндсийг 1922 оноос анхлан тавьсан байдаг. Тухайлбал Ардын Засгийн газраас “Монголын олон засаг ба засаг бус ван, гүнгүүдийн эрх хэмжээний дүрэм” (1922), “Монгол улсын нутгийн захиргааны дүрэм” (1923), “Их шавийн захиргааны дүрэм” (1924) зэргийг боловсруулан гаргасныг баримтлан аймаг, хошуу, сумдыг шинэчлэн зохион байгуулах ажлыг 1923-1925 онд амжилттай хэрэгжүүлсэн байна. Тиймээс тухайн өгүүлэн буй цаг үед Цэцэрлэг мандал уулын аймгийн Хотонт уулын хошуу нэрээр байжээ.

⁵ *Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Үндсэн хууль, түүнд холбогдох зарим актын эмхэтгэл*, Улаанбаатар, 1972, 17-18. *Ардын засгаас 1921-1924 онуудад авсан хувьсгалт арга хэмжээнүүд*, Улаанбаатар, 1954, 15.

⁶ *Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Анхдугаар Их хурал*, Улаанбаатар, 1984, 292.

⁷ Баярмаа, Г. *Эрдэнэ бандида хутагтын аж ахуйн түүхээс*, Магистрын зэрэг горилсон зохиол, Т.61. МУИС-ийн Номын сан.

⁸ Сономдагва, Ц. *Монгол Улсын засаг захиргааны зохион байгуулалтын өөрчлөлт, шинэчлэл, Нэмж засварласан Ч.Банзрагч, О.Батсайхан*. Улаанбаатар, 1998, 228.

Тус хэрэг явдал нь эзэн холбогдогчийн хувьд төдийгүй хамаарах этгээдийн хувьд гэлэн Очир, “өчүүхэн хувраг” хэмээн тэмдэглэгдсэн нэр тодорхойгүй хоёр лам, орон нутгийн Намын үүр, БНМАУ-ын Бүх шашны хэргийг эрхлэх газар (цаашид БШХЭГ гэх) зэргийг хамарч байна. Тухайн үеийн Монголын нийгмийн бүтцэд лам нарын байр суурийг тодруулан авч үзвэл, МАХН-ын Төв Хорооноос 1925 оны 5-р сард нийтлүүлсэн «МАХН-ын шашин шүтлэгийн тухай гол бодлого ба товч тогтоол»⁹ гэх албан ёсны шийдвэрт: «... Лам нар үлэмжхэн тоонд хүрсэн бөгөөд тэдгээрийн байдал төлөв, зорилго суртал харилцан адилгүй, Монголын олон ард, язгууртан зэргийн байдлыг дагалдан салбарласан байх тул лам нар хэмээн нэгэн этгээдэд үзэж болохгүй. Лам нар бол дотроо дээд, дунд, дорд хэмээх гурван анги ялгаварлагдах ба дээд лам нар нь хутагт, хувилгаад, тойд (лам тайж), шавран (гэгээн буюу түүний шадар хүн гэсэн утга бүхий төвд үг), жич дацан хийдийн ба урьд шавийн (8-р богдын Шавийн яамны алба хаагчид) албан хаагч лам нар ба бараа бологчид цөм багтана. Дунд лам нар хэмээсний дотор энгийн гавж, гэвш зэрэг эрдэмд хүрэлцсэн лам нар... дорд хэмээсний дотор бага насны хувраг банди нар бөгөөд дацангуудын тахилч, дуганч, зам нар (тогооч) зэрэг ба ихээхэн лам нарын зарцууд бөгөөд угаасаа үгээгүү хоосон хүмүүс болох тул гавж, гэвш болохын ихээхэн зардал, сүйтгэлийг бүрдүүлж чадахгүй хүмүүс байна... Сүүлийн ангийн хүмүүсийн байдлыг үзвэл... эдгээрийг зодох занчих ба хоол хүнсийг нь хэмжээлэн дарлаж, элдвээр мөлжин ашиглаж байна» гэж дурджээ. Иймээс уг үйл явдалд оролцогч гэлэн Очир нь дээрх гурван ангийн дунд ангилалд, хоёр өчүүхэн хувраг нь дорд ангилалд хамаарах ажээ.

Хэрэг явдал нь дунд давхаргын лам Очир, доорд давхаргын хоёр хуврагийг хийдийн шашны дотоод журмаар шийтгэл оноосон зөрчлөөс үүдэлтэй юм. Лам нар нь Монголын нийгмийн бүтцэд томоохон байр суурь эзлэх бөгөөд ашиг сонирхол, үзэл бодол, улс төрийн үнэлэмжээрээ ч тэр тун өвөрмөц байдалтай нийгмийн томоохон давхраа, бүлгийг бүрдүүлж байв. Энэхүү бүлгийг нас, эрдмийн төлөвшлөөр нь, түүнчлэн нийгэмд эзэлж буй байр суурь, ахуй байдлаар нь ангилж болно¹⁰. Нас, сурлага, эрдэм мэдлэгээр нь авч үзвэл, 6-7 насанд нь багш ламтанд шавь оруулж, банди хэмээн дуудагдаж, 3-4 жилийн дотор төвд бичиг, хурлын уншлагатай болж итгэл, ерөөл цээжилнэ. Багш лам нь шавьдаа ганцаарчлан заах зарчмыг барьж сургах ба шавь нь лам хувраг хүний сахил санваарт үнэнч байхаа тангараглаж, хурал номын ажиллагаанд оролцож эхлүүлнэ. Шашны анхан шатны

⁹ *Монгол Ардын Хувьсгалт Намын тогтоол шийдвэр баримт бичгүүд*, Нэгдүгээр боть. (1920-1928 он) Улаанбаатар, 1981, 265-272.

¹⁰ Болдбаатар, Ж. *Монголын бурхны шашны лам хувраг*, Улаанбаатар, 2010, 66.

боловсролтой болсон 15-20 насны лам-банди нар дотоод ухаан буюу гүн ухааны Дашчойнбал, Гунгаачойлин, Идгаачойлин хийгээд Жүдийн зэрэг дацангуудад хуваарилагдан, шашны дунд боловсролыг олохоор суралцдаг. Эдгээр дацангуудад суралцагчид нь доод, дунд, ахлах хэмээх гурван зиндаанд хуваагдан бурхны шашны ном эрдэмд шамдан, шашны дунд сургуулийг дүүргэхдээ 25-30 орчим насанд хүрсэн байх аж. Сүүлийн шат нь шашны дээд сургууль болно. Өөрөөр хэлбэл, гаарамбын дамжаанд сурч эхэлнэ. Энэ шатанд 10-20 жил өмнөх үзсэнээ давтах, гүнзгийрүүлэх тайлбар хийх, шинээр зохиол бичих зэргээр их төлөв бие даан судална. Шашны дээд сургууль буюу академид суралцсан лам нарын ихэнх нь 50 эргэм насандаа гавж мяндаг хүртэж байжээ¹¹. Гавжийн дамжаа барьсан лам нараас өдрийн од шиг цөөн санваартан бурхны номын гүнзгий шат буюу агын ном буюу тарнийн ухааны жүд дацанд элсэн орно. Суралцагчид нь энэ дацанд багцаагаар 15-20 жил суралцах ба бурханы бодь хутгийг олох онол сургаалийг судлан бясалгадаг байна. Хэрэв сайн суралцаж чадвал 60 орчим насандаа аграмбын дамжаа барьж, шашны дээд мяндаг хүртэнэ¹². Хожим 1925 онд Улсын хоёрдугаар их хурлаас 18 нас хүртэлх сургуулийн насны хүүхдийг сүм хийдэд шавилан суулгах явдлыг хязгаарлан, цэргийн насны лам нараар цэргийн алба хаалгах, дорд лам нарыг аль болохоор хар болгох зэрэг шийдвэр гаргасан байна¹³. Гэвч энэ шийдвэр 1935 он хүртэл бүрэн хэрэгжээгүй юм.

Дээр дурдсан мэдээ баримт, тогтоол журмуудаас үзэхэд гэлэн Очир нь гавж мяндагтай, гэвхүйн тушаалтай болох нь тодорхой тул, тэрээр 50 гаруй насны, эрдэм номд нэвтэрсэн, сүм хийдийн шашны ёс журмыг сахиулах албан тушаалтай нэгэн байжээ. Харин хоёр өчүүхэн хувраг нь 15-25 орчим насны, сүм хийдийн дотоод журмыг сахих үүрэгтэй хүмүүс байсан болов уу гэж үзэж болох юм. Тиймээс “бяцхан хувраг” хэмээх тодотгол нь ном эрдмийн хувьд нимгэн гэх утгаар илэрхийлэгдсэн нь тэдний бичсэнээс илэрхий байна.

Гэлэн Очирын өргөх бичиг

Монгол улсын УТА-ын УТНОНБ-ын баримтын төвд хадгалж байгаа баримтыг бүрэн эхээр нь үзвэл,

Цэцэрлэг мандал аймгийн Хотонт уулын хошууны гэлэн Очир бичгээр БНМАУ-ын бүх шашны хэргийг эрхлэх газарт өргөв¹⁴.

¹¹ Болдбаатар, Ж. *Монголын бурхны шашны лам хувраг*, Улаанбаатар, 2010, 74.

¹² Мөн тэнд. 76.

¹³ Пүрэвжав, С., Дашжамц, Д. *БНМАУ-д сүм хийд, лам нарын асуудлыг шийдвэрлэсэн нь (1921-1940 он)*, Улаанбаатар, 1965, 81.

¹⁴ МУУТА, УТНОНБ-ын баримтын төв, Х-4, Д-1, ХН-474, х-20-22.

Мэдүүлэхийн учир.

Өчүүхэн хүн би бага наснаас тус хошууны хүрээнд сууж, төвд номын сургууль үйлдэж явсаар, гавжийн дамжаа барин мяндагийг хүртээд, ноднин өвөл цаг, харьяат хийдийн эрх баригчид ба хошуудын засаг дарга, түшимэд нарын тушаасныг даган, чойр дацангийн гэвхүйн¹⁵ тушаалыг хүлээн авч, хуучныг мөрдөн, орны тогтоосон дүрэм, дэглэм ёсоор чармайн гүйцэтгэхийг цаг үргэлжид, хэзээ ямагт хичээх атал, энэ хавар цаг, харьяат чойр дацангийн доор зиндааны хоёр бяцхан хувраг удаа дараа хөдөө гарах чөлөө өгнө үү хэмээсэн цаг тухайд, тус дацангийн тогтмол цагийн хурал хурж байсан бөгөөд бас ч чоймчам¹⁶ болоход шахамдан бүхий тул, хуучин дэглэм ба эл учрыг хэлж, удаа дараа чөлөө эс өгсөн учирт, тэрхүү хоёр хөвгүүн тушаал учрыг зөрчиж, дураар хөдөө гарч яваад ирсэн сацуу, харьяат шашны эрх баригчид бид нар хуралдаж, зөвхөн хоёр хөвгүүнийг хэр тэнцүүлэн хуралд мөргүүлэх ба өчүүхэн зэргээр занчиж шийтгэх хэмээснийг тэд нар нэгэнт мөргөж өнгөрсөн, гэтэл манай хошууны ба орон хүрээний хэрэг, ийм явдлыг цөм урьд туслагч явсан Жамьянсүрэн түүний ах Гончигдаш нэгэн төрлийн Дашизэгвэ нар эрхлэн мэдэх бөгөөд мөнхүү намын үүрийн дарга Дашизэгвэ нар харьяат шашны эрх баригчид нар лугаа эрс тэс харилцан зөрж, энэ хэргийг манай үүрийн газар мэдгүй хэмээн цогцлоон аваачиж, тэрхүү хоёр хөвгүүдийг хурлын ёсоор чангалуулахгүй, харьяат үүрийн хурлыг дахин давтан нээж хуралдуулах, харьяат шашны хурлын эрх баригчдыг зарлан дуудаж байцаахуйд, өчүүхэн миний бие хурлын газарт зул өргүүлэхээр нэмээд шийтгэсний дараа, мөн үүрийн хурлыг дахин хуралдаж, өчүүхэн миний гэвхүйн тушаал шилжүүлэн, гавжийг минь устгах ба үүнээс хойш шашны хурлын хэрэгт огт оролцохгүй хэмээн хэлэлцээд, цогчин хурлын нэлээд газар тогтоол бичиг нэгэнтээ хэсэгт уншиж олоод зарласан тухайд өчүүхэн би нэгэнт тушаалыг хүлээсний дараа, шашны хурлын эрх баригчид нийлэн хэлэлцээд, тус дацангийн гэвхүйн оронд өөр бусдыг томилон тавих, гэвч тэр бүр хийх хүн олдохгүй болох хэмээжүхүй. Үүнд өчүүхэн би, өөрийн биед өчүүхэн төдий хорсох сэтгэл үгүй бөгөөд гагцхүү шашин мөргөлийн байдлыг хянаваас, ухвар мөчид багачууд, хөвгүүд нар энэ мэтээр нэгэн орны шашны хурлыг будлиантуулан үймүүлж, шашны хурал ба дэглэм журмыг цалгардуулах

¹⁵ Гэвхүй (гэгсгүй). Төвдөөр “буяны захирагч” гэсэн утгатай. Бурханы шашны нэн эртний тушаал бөгөөд хүрээ хийдийн хурал номын жаяг дэглэмийг эрхлэн сахиулагч, хурлын хуврагуудыг эмхлэн захирагч бөгөөд өдөр бүрийн жасаа хурлын үйлийг ёсоор мөрдүүлэх хурлын үеэр аливаа зохисгүй үйлдлийг таслан зогсоох үүрэгтэй.

¹⁶ Чойнцанг хэлсэн бололтой. Энэ нь 1. Хурлын завсарлагаар явуулдаг сургалт 2. Мөн хурлын завсарлагаар уншдаг номыг ийн хэлдэг гэх.

нь хэн хүний дур болж, хутгалдан самууруулахад хүрчүхүй. Тэр ч байтугай одоо хэр албан тушаалыг хүлээх хүн олдохгүй болж, энэхүү нэгэн орны шашны хэргийг хоосон нэрийн төдий болгоход хүрсэн бөгөөд энэ учрыг үүний урьд МАН-ын Төв Хорооны өргөн мэдүүлсэн зүйл буй тул, эдүгээ Монгол Улсын Бүх Шашны Хэрэг Эрхлэх Газар нэгэн адил өргөн мэдүүлж гүйцэтгэн шийтгүүлбээс зохихын тул, үүнийг БНМАУ-ын Бүх Шашны Хэрэг Эрхлэх Газараа өргөн мэдүүлээд, гүйх нь: Байдал учрыг байцаан томилж, үүнээс хойш харьяат орон хийдийн хурал номын хэргийг хэрхэн болгон явуулсан нь зохих ба бас шашны хурал номын хэргийг энэ мэт Намын үүр ба гишүүд оролцон мэдэж явах буюу эсхүл харьяат шашны хурлын эрх баригчдаас эрхлэн мэдэх алийг нь заан тогтоохыг хүсэхээс гадна, мөн нэгэнт эрдэм ном шалгуулж олсон гавж ба бусад олон мяндагтныг энэ мэт албан тушаал адилаар устгах хэмээх нь шашны ёс суртгаалд нийлэлцэх эсэх зэргийг цөм тогтоон зааж, нийтэд даган явуулах ажааму. Үүний тул өргөв.

15 оны 10 сарын 17

Энэ баримтаас тодруулах хэд хэдэн асуудал урган гарч байна. Юун түрүүнд тухайн цаг дор хүрээ, хийд, дацангийн хурал номын журам, дэглэмийг зөрчсөн лам-банди нарт ямар хэмжээний шийтгэл оногдуулж байсан, тухайн сүм, хийдийн шашны эрх баригчдын шийдвэрлэсэн дотоод асуудлыг гаднаас Намын үүр мэдэж шийтгэх эрхтэй эсэх, энэ мэт асуудалд Бүх Шашны Хэрэг Эрхлэх Газрын эрх үүрэг, оролцоог тодруулах нь зүйтэй. Юуны өмнө гэлэн Очир юунд үндэслэн хоёр хуврагт шийтгэл оноосныг авч үзье. Дээрх өргөх бичигт: “... харьяат шашны эрх баригчид бид нар хуралдаж, зөвхөн хоёр хөвгүүнийг хэр тэнцүүлэн хуралд мөргүүлэх ба өчүүхэн зэргээр занчиж шийтгэх хэмээснийг тэд нар нэгэнт мөргөж өнгөрсөн ...” хэмээжээ. Эндээс харвал, энэ асуудлыг харьяат хийдийн эрх баригчид өөрсдийн дотоод журмаар шийдсэн байна. Тухайн цаг үед сүм хийд, лам нарын асуудлыг Монгол Улсын бүх хийд 1937 он хүртэл олон жилийн уламжлалт дэг ёсоор зохицуулж байв. Тэр уламжлал нь аливаа хүрээ хийд, дацангийн дэг жаягийг зөрчигч лам хувраг, эгэл хүнийг малаар торгох ял буюу ес суурьтай малын торгуулийн ял, ташуураар занчих, сахилыг нь эвдэх гэсэн үндсэн ялыг хэрэглэж хариуцлага хүлээлгэдэг байжээ. Тухайлбал: Хэвт Ёстын үед анх боловсруулан дагаж мөрдсөн “Жинхэнэ дагаж явах хууль, дүрэм”-д зааснаар” лам банди нар одсон гэртээ хонох ба тэргүүн ламд мэдүүлэлгүй зоригоор явах ба лам нарыг авч одох хүн тэргүүн ламд хэлэлгүй авч одох ба гэрт хонуулах бол зоригоор явсан, хоносон лам, бандиас гурваад есөн мал торгож засагт авсугай. Зоригоор

авч одсон хүнийг харьяат явдлын яаманд тушаан өгч яллуулсугай” хэмээжээ. Түүнчлэн “хороо харчуудын гэр хашаанд өдөр цагт зоргоор орсон ба гудамжинд явж баригдсан лам, банди нарыг Эрдэнэ Шанзудбагийн яаманд нягтлан байцаан шүүгээд, - гагцхүү тэмдэгт мод хүлээн авах дүрмийг зөрчин явсныг нь их гэсгүй нарт тушаан өгч, бэрээгээр занчиж гэсгээн, гучин өдөр их хуралд өнжүүлэлгүй хуруулж, өдөр тутам зуунтаа мөргүүлсүгэй¹⁷” хэмээн зааснаар уг хэргийг шийтгэсэн бололтой.

Гэлэн Очирын бичиг өргөсөн БНМАУ-ын БШХЭГ бол 1925 онд Шашны түр захиргаа, 1926 онд орон нутгийн зарим томоохон сүм хийдүүдийн дэргэд шашны захиргаа нэрээр байгуулагдсан байна. 1925 оны 7 дугаар сарын 23-нд Монгол Улсын Засгийн Газраас Дотоод явдлын яам, МАХН-ын ТХ-нд явуулсан бичигт: Дашчоймбал, Гунгаачойлин, Идгаачойлин зэрэг гурван дацангаас 24 хүн, Дэчингалба, Жүд, Манба, Зурхай, Бадам-Ёга, Ламрим зэргийн зургаан дацангаас нижгээд нийт 30 хүнийг томилон шашны Бага хурал байгуулах, олон аймаг хошууд ба хүрээ, гандангийн газарт бүхий аль эрдэмтэн мэргэдийн дотроос тусгайлан долоон хүнийг Бага хурлаар сонгон гаргаж, харьяат улсын доторх бүх шашны хэргийг эрхлүүлэх, шашны хурлыг түр эрхлэх газрыг Зүүн хүрээний дунд хуучин Шанзудбын Яамны хашаанд нээн байгуулахаар хэлэлцсэн байна¹⁸. Тухайн цаг үед тус улсын доторх зуун мянгаад лам нар бүхий олон зуун сүм хийдийн хэргийг төрөөс шууд удирдаж, хяналт тавих болсон нь Үндсэн хууль зөрчихөд хүрэх учир большевикуудын зааварласны дагуу 1926 онд хуралдсан МАХН-ын V их хурлаас хойш МАХН, УБХ, Засгийн газар улсын хэмжээний бүх шашны асуудлыг чанд хянаж байх болсон юм. Энэ үүднээс энэхүү БШХЭГ байгуулагдсан байна. Тус газрын үүрэг бол МАХН-ын заавраар шашны аливаа асуудлыг байнга хянаж байхад оршиж байв. Иймээс энэ байдлыг лам хуврагууд эрс эсэргүүцэж байсны нотолгоо нь энэ мэдүүлгийг өргөсөн гавж Очирын бичиг юм. Харин Төв ба орон нутгийн засаг захиргааны байгууллагууд нь сүм хийдийн дотоод хэрэгт шууд оролцож болохгүй байснаас шалтгаалан, сүм хийдэд тавих төрийн хяналтад бэрхшээл учирч байсан хийгээд түүнчлэн дорд лам нарыг дарлаж байсантай холбогдуулан шашны захиргаа байгуулахыг дорд лам нар хүссэн хэмээн судлаач С.Пүрэвжав, Д.Дашжамц нар өмнөх судалгааны ажлуудаар үзжээ. Гэлэн Очирын хэрэг явдалд орон нутгийн намын үүр оролцсон явдлын үндэслэлийг авч үзье.

¹⁷ Урангуа, Ж., Баярсайхан, Б. *Жинхэнэ дагаж явах хууль дүрэм [эх бичгийн судалгаа]*, Улаанбаатар, 2004, 10.

¹⁸ МУУТА, Х-1,Д-2,ХН-36, тал 37-38

Тухайн үед буюу 1925 онд МАХН-ын IV их хурлаар түр баталсан МАХН-ын мөрийн хөтөлбөр дүрэм болон МАХН-ын бусад албан ёсны шийдвэрт Намын бүх шатны аль ч байгууллага шашны ямар ч асуудалд орох эрх үүрэггүй байв. Үүнийг тодруулбал, МАХН-ын дүрмийн 22 дугаар зүйлд зааснаар, Ардын Хувьсгалт Намын зохион байгуулалт нь Нэгд: Бүх Монголын Ардын Намын их хурал ба Намын Төв Хороо; Хоёрт: Аймгийн хурал ба аймгийн намын хороо; Гуравт: Хошууны хурал ба хошууны хороо; Дөрөвт: Хотын хурал ба хотын хороо; Тавд: Сум, баг, үүрүүдийн хурал ба үүрийн хэрэг эрхлэх газар¹⁹ гэсэн бүтэцтэй байна. Тус дүрмийн 49-52 дугаар зүйлд намын үүрүүдийн тухай, бүтэц, эрх, үүргийг заажээ. Түүнд зааснаар, намын үүр бол намын салбар тул, тус улсын эдийн засгийн хийгээд засаг төрийн явдалд идэвхтэйгээр оролдвол зохино хэмээжээ. Үүнийг товч дүгнэвэл, аливаа намын байгууллага, салбар нь сүм хийдийн дотоод асуудалд хөндлөнгөөс шууд оролцох эрхгүй байжээ. Гэтэл Хотонт сумын намын үүр нь тус хошууны хийдийн дотоод асуудалд дур мэдэн хөндлөнгөөс оролцож намын дүрэм зөрчсөн байна. Гэтэл үүнийг засаж залруулах үүрэгтэй МАХН-ын Төв Хороо тус хошууны чойр дацангийн гэвхүй Очирыг гэмт хэрэг өдүүлсэн мэтээр үзэж МАХН-ын ХБТК-т уламжлан хариуцлага тооцож арга хэмжээ авахыг даалгасан нь тухайн үед улс төрийн нам шашны хэрэгт хөндлөнгөөс шууд гар дүрэн оролцож эхэлж байсныг харуулж байна

Дараагийн баримт нь гэлэн Очирын МАН-ын Төв Хороонд давхар өргөн мэдүүлсэн өргөх бичгийн дараах шатны баримт бололтой. Доорх баримтаар гэлэн Очирын мэдүүлгийг Монгол Ардын Намын суртлын хэлтэсээр хэлэлцээд, улмаар Хянан Байцаах Төв Комисст (цаашид ХБТК гэх Улаанбаатар хотноо) шилжүүлсэн нь мэдэгдэнэ. Түүнийг бүрэн эхээр үзвэл, дараах мэт.

Арван таван оны арван сарын 27

Гэлэн Очироос тэмцэн мэдүүлсэн гишүүн Дамдинсүрэнгийн хэргийг Хянан Байцаах Төв Комиссын дарга нарт явуулах хуудасны эх илгээв. Хуудсаар явуулах учир, Суртлын хэлтсээс энэ оны 10 сарын 24-ний өдөр, тус хорооны зохион байгуулах зөвлөлийн 8 дугаар хурлын 6 дугаар зүйлд, Цэцэрлэг мандалын аймаг дахь намын хорооноос гэлэн Очирын тэмцэн мэдүүлсэн хэргийг гишүүн Даишээгэвэ хэмээх Дамдинсүрэн байцаалгаж, түүний мэдүүлснийг жасаас байцаан гүйцэтгэн шийтгэмүй хэмээн ирсэн хэргийг хэлэлцээд, энэ хэргийг Хянан Байцаах Төв Комисст шилжүүлэн явуулахыг хянан шийтгүүлэхээр

¹⁹ Монгол Ардын Хувьсгалт Намын тогтоол шийдвэр баримт бичгүүд (1920-1928), Улаанбаатар, 1981, 312.

*тогтов хэмээсэн. Үүнд: уг хэргийн бичгүүдэд хуудас дагалдуулан хүргүүлж, үүнийг Хянан Байцаах Төв Комиссын дарга нарт явуулсанд, байцаан үзэж эл хэргийг гүйцэтгэн шийтгэсүгэй хэмээсэн. Үүний тул илгээв*²⁰.

1925 оны МАХН-ын Төв Хорооны дүрэмд зааснаар, “Намын их хурлын чөлөө цагт намыг удирдах дээд газар нь Намын Төв Хороо болно... НТХ-ны тэргүүлэгч гишүүд, гадаад лугаа харилцах явдал, цэргийн засаг, аж ахуй ба албан гувчуурын хэргүүд, мөн олон албаны газрыг жолоодох ба эрдэм соёлд урагш дэвшин боловсрох явдлын бодлого, шүүн таслах хэрэг ба шашны тухайн зэрэг улсын бүхий л байдалд холбогдол бүхий элдэв хэргүүдийг шийтгэн явуулна²¹” хэмээн заажээ. Түүнчлэн намын хороо нь зохиол, суртал, эмэгтэйчүүд, ерөнхий гэсэн дөрвөн хэлтэстэй байхаар тусгасан байдаг. Эндээс явцыг дүгнэхэд гэлэн Очирын мэдүүлснийг МАХН-ын Төв Хорооны Суртлын хэлтсээр юуны өмнө байцаагаад, Хянан Байцаах Төв Комисст шилжүүлжээ. 1925 оны долдугаар сарын МАХН-ын Хянан Байцаах Комиссын түр дагаж явах дүрэмд зааснаар, Улаанбаатар хотноо Хянан Байцаах Төв Комисс, аймгуудад аймгийн хянан байцаах комиссуудыг байгуулах ба, Хянан Байцаах Төв Комиссын таван гишүүн хоёр орлогч гишүүдийн хамт бүр намын их хурлуудаар сонгох бөгөөд аймгийн хянан байцаах комиссын гишүүд гурав ба нэгэн орлогчийн хамт аймгийн намын тогтмол хурлаар сонгогддог журамтай аж. Хянан Байцаах Комисс нь нам ба намд ороогүй ард олноос мэдүүлсэн аливаа хэрэг зүйлийг авч хэлэлцэн тасалсан зэрэг мэдээ зүйлийн байдлыг баримталж хянан байцаах хэргийг явуулна. Тиймээс энэхүү чиг үүргийн дагуу гэлэн Очирын өргөсөн бичгийг Хянан Байцаах Төв Комиссын дарга нарт шилжүүлсэн ажээ.

Сүүлийн баримт нь БНМАУ-ын Бүх Шашны Хэрэг Эрхлэх Газраас Намын Төв Хороонд хаяглагджээ. Энэхүү баримтыг бүрэн эхээр нь үзвэл, дараах мэт.

*БНМАУ-ын шашны хэргийг эрхлэх газрын бичиг.*²²

Хувьсгалт Ардын Намын Төв Хороонд илгээв. Явуулсан учир, Арван тавдугаар оны арван сарын арван наймны өдөр, тэргүүлэгчдийн хуралдсан Арван хоёрдугаар хурлын нэгдүгээр зүйлд.

Цэцэрлэг мандал аймгийн Хотонт уулын хошууны гэлэн Очироос, харьяат хошуудын хийд, чойр дацангийн гэсгүйн тушаал бүхий цаг, хурлын жаяг дэглэм

²⁰ МУУТА, УТНОНБ-ын Баримтын төв, Х-4, Д-1, ХН-446, Тал-76.

²¹ Монгол Ардын Хувьсгалт Намын тогтоол шийдвэр баримт бичгүүд (1920-1928), Улаанбаатар, 1981, 275.

²² МУУТА, УТНОНБ-ын Баримтын төв, Х-4, Д-1, ХН-474, Тал-18-19.

тушаалыг эс дагасан намын гишүүн ба гишүүн бус хоёр бяцхан хуврагийг шашны хурлын эрх баригчид лугаа зөвлөлдөн, жаягийн ёсоор шийтгэсний улмаас, Очир миний бие зул өргүүлэх зэргээр шийтгэгдэж, басхүү гэсгүйн тушаалыг гавж мяндагийн хамтаар устгасан нь эдүгээ үүнээс урагш Намын үүр ба гишүүд шашны хэргийг эрхлэн мэдэж явах ба ном эрдмийг шалгуулж олсон мяндагийг устгах нь шашны ёс суртгаалд нийлэлцэх эсэхийг заан эрж(хүсч), нийтээр дагаж явуулахыг гуйсугай хэмээн үүний урьд, энэхүү учраа²³ Намын Төв Хорооноос мэдүүлсэн учрыг гаргаж өргөн мэдүүлсэн хэргийг хэлэлцээд, хурал номын хуврагийг захирах, захирагдах ёсоор харьяат захирах эрх баригчид эрхгүй жаяг дэглэмийн ёсоор захирч баримталбаас зохих бөгөөтөл, намын үүрийн гишүүдээс ийнхүү шашин хурлын захирах захирагдах ёсоор шийтгэсэн хэргийг цуцлан, харин гэдрэг шийтгэх тушаал ба мяндагийг устгасан явдал нийлэлцэх эсэхийг шийдэж мэдэхгүйн дээр, харин ч харьяат хувраг лам нарын захирагдах ёс, шашны хурал дэглэм улмаар цалгардахад хүрэх болуужин хэмээхийн тул, үүнээс урагш²⁴ хувраг лам нарыг жаяг ёсоор баримтлан захирч, цээрлүүлэн шийтгэж дагаж явуулбаас болох эсэх, бас ч нам, эвлэлийн лам гишүүн хүний шарын шашны хурал номд өөрийн дуртай санаагаар хуралдаад, тэр тухайд мөн шарын шашны ёс дэглэмийг гажуудуулбаас, ламын ёсоор жаяг дэглэмийг дагуулан захирах, эсбээс (хэрэг яахин гүйцэтгүүлж)²⁵ бусад лам нарын дуурайн одох гэлийг арилгаваас зохих явдлыг Намын Төв Хорооноос мэдүүлэхийн хамтаар тогтоон заалгаж, дагаж явуулсугай хэмээн хэлэлцэн тогтов хэмээсэн. Иймийн тулд, уг өргөдлийг хэвээр тусгай сийрүүлэн, үүнийг Хувьсгалт Ардын Намын Төв хорооноос мэдүүлэн явуулсанд, хүрмэгц бичгийн доторхыг байцаан толилж, тогтоон шийтгэж даган явуулах ажсааму. Үүний тул илгээв.

Монгол улсын арван тавдугаар он арван сарын 29 дугаар 21 Хамба ...

Тушаан шийтгэх түшмэл Сүрэн

Бичгийн агуулгаас үзэхэд БНМАУ-ын БШХЭГ нь гэлэн Очирын өргөсөн хэргийг хэрхэн шийдвэрлэхээ мэдэхгүйн дээр хожим иймэрхүү асуудал гарвал хэрхэн, яаж шийдвэрлэхийг МАХН-ын Төв Хороогоор шийдвэрлүүлээд түүнийг

²³ Учирт, үүний тул – гэсэн утгатай.

²⁴ Үүнээс урагш – үүнээс хойш гэсэн утгыг илэрхийлнэ.

²⁵ Ажил хэргийг хэрхэн хийлгэснээр бусад лам нар дуурайн авирлах явдлыг зогсоох арга бодлогыг Намын Төв Хорооноос зааж зааварлана уу гэж хүссэн ба тийнхүү зааварчилгаа ирвэл тэр дагуу баримтлан шийдвэрлэе гэсэн утга.

дагаж шийтгэхийг хүсчээ. Ийнхүү БШХЭГ нь Үндсэн хуулийн хүрээнд зохих журмын дагуу албан бичгээ үйлдсэн боловч хууль журмыг дагах эсэхээ МАХН-ын Төв Хорооноос асууж шийдвэр хүсч байгаа нь тус газрын эрх мэдлийн хэмжээ хязгаарыг илтгэхийн сацуу шашны асуудлаар дээд эрх мэдэлгүй зөвхөн нам улс төрийн төдийгүй шашны дээд эрхийг гартаа авсныг илэрхийлж байна. Эрх зүйн үүднээс үзвэл БШХЭГ нь төрийн захиргааны эрх зүйн нэгэн институт болжээ.

Монгол улсын түүхэнд шашныг төрийн хэргээс тусгаарласан, эрх зүйн хэм хэмжээгээр тусгайлан зохицуулсан анхны хууль тогтоомж бол 1921 оны 11 дүгээр сарын нэгний өдөр Засгийн газраас тогтоон гаргасан “Ардын засгийн газар ба Богд хааны хооронд байгуулсан тангарагийн гэрээ” хэмээх дүрэм юм. Монгол Улсын 1924 оны Анхдугаар Үндсэн хуулиар тус улс дахь шашны хэргийг төрөөс зохицуулах суурь зарчим, баримтлах бодлогын эрх зүйн үндсийг тодорхойлон заасан нь шашны харилцааны зохицуулалтын шинэ шатны эхлэл, цаашдын хэрэгжилтийн хэм хэмжээ болсон байна. Түүнчлэн 1926 онд “Тус улсын төр, шашны хэргийг тусгаарлан явуулах тухай дүрэм”²⁶ гарч шашин шүтлэг, сүм хийд, лам нартай холбоотой өргөн олон асуудал, харилцаа, үйл ажиллагааг хооронд нь харилцан уялдуулж цогцолбор байдлаар тусган хэм хэмжээлэн зохицуулжээ. 1934 оны “Төр шашныг тусгаарлан явуулах тухай”²⁷ хуулиар, орон хийдийн дотоод журмыг зөрчсөн учир ламд шашны захиргаанаас ямар нэгэн шийтгэл оногдуулдаг явдлыг хориглосон байна.

Дүгнэлт

Эцэст нь Цэцэрлэг Мандал аймгийн Хотонт уулын хошууны гэлэн Очирын БНМАУ-ын Бүх Шашны Хэргийг Эрхлэх Газарт болон МАН-ын Төв Хороонд өргөсөн бичиг, БНМАУ-ын Бүх Шашны Хэргийг Эрхлэх Газраас Намын Төв Хороонд илгээсэн бичигт эрх зүйн шинжилгээ хийсний үр дүнг дүгнэвэл,

1-г, гавж Очир бол зөрчил гаргасан хоёр хуврагт дацангийн дотоод журмын дагуу шийтгэл ногдуулсан нь илэрхий байна. Тиймээс Гэлэн Очир нь өөрийн үндсэн эрх, эрх чөлөөг хамгаалах, тухайн нийгмийн буруу голдрил, үйл явцыг анзаарсан, шаардлагаа зөв тодорхойлж бичиг өргөжээ хэмээн үзэж байна.

2-т, гэлэн Очирын мэдүүлсэн гомдол болбоос МАХН-аас шашны хэрэгт шууд оролцох болсныг лам хуврагууд эрс эсэргүүцэж байсны бодит нотолгоо болж байна. Энэ нь төр, шашны харилцааг тусгаарлах үйл явцад гарсан нарийн ээдрээтэй асуудлуудыг хөндсөн, анхны жишигүүдийн нэг байлаа. Тус үйл явдал нь 1925 онд болсон бөгөөд 1921 оны Тангарагийн гэрээ, 1924 оны улсын Анхдугаар Үндсэн хуулиар төр шашны харилцааг тусгаарлах анхны зохицуулалтыг хийсний дараахан үе юм.

3-т, Түүнчлэн шашны асуудлыг тухайн цаг үед үнэн хэрэгтээ Бүх Шашны Хэрэг Эрхлэх Газар бус МАХН-ын Намын Төв хороо шийдвэрлэж байгаа нь тус нам большевикуудын заавар, хяналтын дагуу шашны асуудлыг өөртөө төвлөрүүлж тухайн цагт төрөөс баталсан хуулийн заалтыг үл хайхран сүсэгтнүүд ба лам хуврагуудыг аль болохоор хавчин хязгаарлах шашныг элдвээр гутаан доромжлоход чиглэсэн тууштай бодлого хэрэгжүүлж байсны нотолгоог дээрх гавж Очирын зарга МАХН-ын ТХ –ны шийдвэр нотолж байна. МАХН 1925-1928 онд лам нарт захиргааны хариуцлага хүлээлгэх нь давамгайлж байсан бол 1929-1932 онд шорон гяндан буюу эрүүгийн хариуцлага хүүлээлгэж хэдэн сараас 10 жил, цаазаар авах ялаар залхаан цээрлүүлж хомроглон егүүтгэж байсныг олон үгээр нуруших нь илүүц билээ.

Abstract

This article aims to explain from the point of historical and legal background to the suit filed by Ochir, who was a gelen of the KhotontUul banner of the Tsetserlegmandalaimag to the Office of All Religion, and the responding documents from the Office of All Religion. The historical documents are kept at the National Archive of Mongolia under the catalogues of X-4, Д-1, ХН-446, and ХН-474. This paper is to make analysis through giving explanations to the individuals involved in the events, while explaining some of the terms and terminologies used in the texts. During this period, Mongolian government issued several documents regarding separating the state from religious entities while they followed cautious policy in the reality. The suit filed by Ochirgelen was one of the documents that showed the processes to separate the state from religious entities.

Ном зүй

Архивын баримт

1. МУУТА, УТНОНБ-ын Баримтын төв, Х-4, Д-1, ХН-474, х-20-22.
2. МУУТА, УТНОНБ-ын Баримтын төв, Х-4, Д-1, ХН-446, Тал-76.
3. МУУТА, УТНОНБ-ын Баримтын төв, Х-4, Д-1, ХН-474, Тал-18-19.
4. МУУТА, Х-1, Д-2, ХН-36, тал 37-38.

Баримт бичгийн эмхтгэл

1. Урангуа, Ж., Баярсайхан, Б. *Жинхэнэ дагаж явах хууль дүрэм /эх бичгийн судалгаа/*. Улаанбаатар, 2000.
2. *Бүгд найрамдах Монгол Ард Улсын Үндсэн хууль түүнд холбогдох зарим актын эмхэтгэл*. Улаанбаатар, 1972.
3. *Ардын засгаас 1921-1924 онуудад авсан хувьсгалт арга хэмжээнүүд*. Улаанбаатар, 1954.
4. *Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Анхдугаар Их хурал*. Улаанбаатар, 1984.
5. *Монгол Ардын Хувьсгалт Намын тогтоол шийдвэр баримт бичгүүд*. Нэгдүгээр боть. (1920-1928 он) Улаанбаатар, 1981.
6. Амарсанаа, Ж нар. *Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл*. Гуравдугаар боть. 1926 VI сар-1936. Улаанбаатар, 2010

Судалгааны бүтээл

1. Болдбаатар, Ж. *Монголын бурхны шашны лам хуврага*. Улаанбаатар, 2010.
2. Пүрэвжав, С., Дашжамц, Д. *БНМАУ-д сүм хийд, лам нарын асуудлыг шийдвэрлэсэн нь. (1921-1940 он)*. Улаанбаатар, 1965.
3. Сономдагва, Ц. *Монгол Улсын засаг захиргааны зохион байгуулалтын өөрчлөлт, шинэчлэл*. Нэмж засварласан Ч.Банзрагч, О.Батсайхан. Улаанбаатар, 1998.